



БАЯНХОНГОР АЙМГИЙН
БААЦАГААН СУМЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ХУРАЛДААНЫ ТОГТООЛ

2022 оны 12 сарын 19 өдөр

Дугаар

8/03

Баянсайр

Г Бэлчээр ашиглалтыг хариуцлагажуулах
журам батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.10, 35.1.14, 35.1.17 дахь заалт, Газрын тухай хуулийн 52 дугаар зүйлийн 52.6, Малын тоо толгойн албан татварын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1, 5 дугаар зүйлийн 5.1, 6 дугаар зүйлийн 6.2, 7 дугаар зүйлийн 7.1, 7.2-д заасныг тус тус үндэслэн сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит VIII хуралдаанаас **ТОГТООХ нь:**

1. Бэлчээр ашиглалтыг хариуцлагажуулах журмыг хавсралтаар баталсугай.
2. Журмыг ард иргэдэд танилцуулан хэрэгжилтийг хангаж ажиллахыг сумын Засаг дарга (С.Энхтөр) –д даалгасугай.
3. Журмын холбогдох бичиг баримтыг бүрдүүлэн Хууль зүй, дотоод хэргийн яамны хууль зүйн бодлогын газрын захиргааны хэм хэмжээний актын хяналт, бүртгэлийн хэлтэст бүртгүүлэхийг сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын нарийн бичгийн дарга (Ц.Энхтуяа)-д даалгасугай.
4. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн бодлогын хорооны дарга (Ц.Дэмчиг)-д үүрэг болгосугай.

ДАРГА  Ж.ГАНБАТ



0221065
Тогтоол-2022




МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ ЗҮЙ,
ДОТООД ХЭРГИЙН САЙД

Засгийн газрын V байр, Б.Ширэндэвийн гудамж 8/4,
Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, 15160
Утас/Факс: (976-51) 26 75 33,
Цахим шуудан: info@mojha.gov.mn,
Цахим хуудас: www.mojha.gov.mn

2023.02.10 № 1/795
танай 2023.02.01-ны № 1/40-Т

БАЯНХОНГОР АЙМГИЙН
БААЦАГААН СУМЫН ИРГЭДИЙН
ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ДАРГА
Ж.ГАНБАТ ТАНАА

Баянхонгор аймгийн Баацагаан сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын “Бэлчээр ашиглалтыг хариуцлагажуулах журам батлах тухай” 2022 оны 8/03 дугаар тогтоолыг Захиргааны ерөнхий хуулийн дагуу хянан үзээд захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн бүртгэлийн 6155 дугаарт бүртгэж хүргүүлэв.



Х.НЯМБААТАР

151601034
А5 Файл.2023

Сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын
20~~22~~ оны ~~12~~ дугаар сарын ~~19~~ -ны өдрийн ээлжит
~~VIII~~... дугаар хуралдааны ~~8/23~~ тогтоолын хавсралт

БЭЛЧЭЭР АШИГЛАЛТЫГ ХАРИУЦЛАГАЖУУЛАХ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Энэхүү журмын зорилго нь бэлчээр ашиглалтыг тухайн орон нутгийн бэлчээрийн экологийн чадавхид суурилсан аргачлалаар төлөвлөх, бэлчээрийг түүний нөөц, даацад нь тохируулан байгалийн жамаараа нөхөн сэргэх боломжийг бүрдүүлсэн төлөвлөгөөний дагуу улирлын хуваарьтайгаар, зүй зохистой ашиглаж, хамгаалах дадлыг төлөвшүүлэхтэй холбогдон нутгийн удирдлага, бэлчээр ашиглагчдын хооронд үүсэх харилцааг зохицуулахад оршино.

1.2. Газрын тухай хуулийн 50.1.1-т заасны дагуу бэлчээрийн төлөв байдал, чанарыг хадгалах, байгалийн аясаар болон хүний үйл ажиллагааны улмаас хөрсний үржил шим буурах, бэлчээрийн ургамлын бүрхэвч талхлагдах, хөрс элэгдэх, эвдрэх, хуурайших, намагжих, давсжих, бохирдох, хордохоос сэргийлэх арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардагдах зардлын тодорхой хувийг бэлчээр ашиглагч-малчин хариуцна.

1.3. Энэ журмын 1.2-т заасан зардал нь бэлчээр ашиглалтын гэрээгээр тохирсны дагуу БАХ-ын гишүүн-малчны тухайн бэлчээрийн даацаас хэтэрсэн малыг хонин толгойд шилжүүлснээр төлөх мөнгөн дүнгээс бүрдэнэ.

Хоёр. Бэлчээр ашиглалтыг төлөвлөх

2.1. Бэлчээр ашиглалтыг төлөвлөхдөө дараахь зарчмыг баримтална:

2.1.1. Бэлчээрийн экологийн чадавхид суурилах;

2.1.2. Бэлчээр ашиглагчдын тэгш оролцоог хангах.

2.2. Тухайн жилийн бэлчээр ашиглалтын төлөвлөгөө (цаашид "бэлчээр ашиглалтын төлөвлөгөө" гэх) нь дараах шаардлагыг хангасан байна:

2.2.1. Бэлчээрийн төлөв байдал, чанарт хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээний дүнд үндэслэсэн байх;

2.2.2. Бэлчээрийг улирлын хуваарьтайгаар ашиглах, сэлгэх, өнжөөх хуваарийг гаргасан байх;

2.2.3. Бэлчээрийг хамгаалах, байгалийн жамаараа нөхөн сэргэх боломжийг бүрдүүлсэн байх;

2.2.4. Бэлчээр дэх уст цэг, хужир мараа бүхий газрыг нийтээр ашиглах нөхцөлийг бүрдүүлсэн байх.

2.3. Газрын тухай хуулийн 52.2-т заасны дагуу тухайн жилийн бэлчээрийн гарц, иргэдийн саналыг харгалзан өвөлжөө, хаваржааны бэлчээрийг малаас чөлөөлөх, мал оруулах хугацааг сумын Засаг дарга тогтооно.

2.4. Бэлчээр ашиглалтын төлөвлөгөөний төслийг сумын газрын даамал боловсруулж холбогдох багийн Иргэдийн Нийтийн Хурлаар хэлэлцүүлэхээр хүргүүлнэ.

2.5. Бэлчээр ашиглалтын төлөвлөгөөг багийн Иргэдийн Нийтийн Хурлын саналыг тусган Газрын тухай хуулийн 20.1.2-т заасны дагуу сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал батална.

2.6. Сумын Засаг дарга бэлчээр ашиглалтын төлөвлөгөөг үндэслэн бэлчээрийг Газрын тухай хуулийн 52.2-т заасны дагуу болзол, гэрээгээр малчдад хэсэг, бүлэг (цаашид "БАХ" гэх)-ээр ашиглуулах асуудлыг шийдвэрлэж, зохион байгуулна.

2.7. Бэлчээр ашиглалтын чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа гадаад улс, донор байгууллагын төсөл хэрэгжүүлэгч нэгж нь бэлчээр ашиглалтын жилийн төлөвлөгөөг боловсруулах, түүнийг хэрэгжүүлэхэд баг, сумын Засаг даргатай хамтран ажиллаж болно.

Гурав. Бэлчээрийн даац тооцох

3.1.Багийн Засаг дарга харъяалах багийн бэлчээрийн даацад үндэслэн дараах тооцооллыг гаргаж жил бүрийн 9 дүгээр сарын 15-ны дотор багийн Иргэдийн Нийтийн Хурлаар хэлэлцүүлэн олонхийн саналаар батлан, сумын Засаг даргын Тамгын газарт хүргүүлнэ. Үүнд:

3.1.1. Газрын төлбөрийн тухай хуулийн 6.2-т заасан итгэлцүүрээр хонин толгойд шилжүүлж тухайн багийн бэлчээр нутагт өвөлжих, хаваржих малын тооны дээд хязгаарыг дараах аргачлалаар тогтоох:

Өвөлжих, хаваржих малын
тооны дээд хязгаар =

бэлчээрийн нийт ургацын хэмжээ

180 хоног*1,0 кг

3.1.2. Тухайн багийн малчин өрхийн нэг гишүүнд ногдох малын тоог дараах аргачлалаар тогтоох:

малчин өрхийн нэг гишүүнд
ногдох малын тоо =

Өвөлжих, хаваржих малын тооны дээд хязгаар
багийн нийт иргэдийн тоо

3.2.Тавиул малыг тухайн маллаж байгаа малчин өрхийн малын тоонд оруулж тооцно.

3.3. Энэ журмын 3.1-д заасан тооцоололд дараахь мэдээллийг хавсаргана:

3.3.1. Энэ журмын 1.2-т заасан зардлыг бэлчээрийн даацаас илүү гарсан малын (хонин толгойд шилжүүлсэн) тоогоор тооцож гаргасан мөнгөн дүн;

Дөрөв. Бэлчээр ашиглалтын төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд төрийн байгууллагын хэрэгжүүлэх үйл ажиллагаа

4.1. Сумын Хөдөө аж ахуйн тасаг дараах үйл ажиллагааг хэрэгжүүлнэ:

4.1.1. БАХын гишүүн-малчдад уламжлалт бэлчээр ашиглалт, бэлчээрийг зөв ашиглах мэдлэг олгох, доройтсон бэлчээрийг нөхөн сэргээх, сайжруулах талаар сургалт зохион байгуулах;

4.1.2. Багийн Иргэдийн Нийтийн Хурлаас гаргасан саналыг харгалзан тухайн багийн бэлчээрийн усан хангамжийг нэмэгдүүлэх арга хэмжээ авах;

4.1.3. Бэлчээрийн хөнөөлт мэргэгчид, хортон шавжтай тэмцэх ажлыг малчдын оролцоотой зохион байгуулах;

4.1.4. Фото мониторингийн дүнд тулгуурлан тухайн жилд малын тоог бэлчээрийн даацад нийцүүлэхэд чиглэсэн сүргийн зохистой бүтэц, харьцаа, шилэн сонголт, чанар болон мал аж ахуйг үр ашигтай эрхлэн явуулах талаар зөвлөмж гаргах.

4.2. Сумын Цаг уурын өртөө дараахь үйл ажиллагааг хэрэгжүүлнэ:

4.2.1.Тухайн баг, сумын саналыг үндэслэн фотомониторингийн цэгийн тоог нэмэгдүүлэх арга хэмжээ авах;

4.2.2. Сум, багийн түвшинд бэлчээрийн даацыг тогтоон, өвөлжиж хаваржих боломжит малын тоог тодорхойлсон дүнгийн хамт жил бүрийн 09 дүгээр сарын 10-наас 20-ны дотор аймаг, сум, багийн Засаг даргад хүргүүлэх;

4.2.3. Энэ журмын 4.4.2-т заасан саналыг харгалзан үзэж боломжтой тохиолдолд үүлэнд зориудаар нөлөөлөх генератор байршуулан, мэргэжил арга зүйн зөвлөгөөгөөр хангах.

4.3. Газрын даамал дараах үйл ажиллагааг хэрэгжүүлнэ:

4.3.1. Сумын нийт бэлчээрийн хэмжээ, байршлыг газрын нэгдмэл сангийн бусад ангиллын газартай давхцуулахгүйгээр зураглан мэдээллийн санд оруулах;

4.3.2. Газрын тухай хуулийн 58.5-д заасны дагуу бэлчээр, хадлангийн газрын төлөв байдал, чанарын хянан баталгааг 5 жил тутамд мэргэжлийн байгууллагаар хийлгэх талаар санал өгөх;

4.3.3. Бэлчээр ашиглалтын гэрээ байгуулахад шаардагдах хавсралт, зурган мэдээлэл гаргах, бэлчээр ашиглалтын гэрээг газрын мэдээллийн нэгдсэн санд бүртгэх, гэрээний хэрэгжилтийн байдалд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд тайлагнах;

4.3.4. Өвөлжөө, хаваржаа, худаг, уст цэгийн байршлыг тогтоож мэдээллийн сан үүсгэх, тогтмол шинэчлэх;

4.3.5. Сумын хилийн маргаантай байгаа асуудлыг судлан шийдвэрлүүлэх санал боловсруулан холбогдох байгууллагад хүргүүлэх;

4.3.6. Бэлчээр ашиглагчдын хэсэг (БАХ)-ийн улирлын бэлчээр бүр дээр фотомониторингийн цэг байгуулж жил бүрийн 8 дугаар сард багтаан ашиглалтын үр нөлөөг хянах фотомониторингийн мэдээлэл цуглуулах, мэдээлэл боловсруулж улсын хэмжээний нэгдсэн санд оруулах, шийдвэр гаргагчид болон малчдыг мэдээллээр хангах.

4.4. Багийн Иргэдийн Нийтийн Хурал дараах үйл ажиллагааг хэрэгжүүлнэ:

4.4.1. Энэ журам, тухайн жилийн бэлчээр ашиглалтын төлөвлөгөө, тайланг хэлэлцэх;

4.4.2. Бэлчээрийн сан бүрдүүлэлт, зарцуулалтын байдалд хяналт тавих.

4.4.3. Жил бүрийн 5 дугаар сарын 1-ний дотор хуралдаж, өмнөх жилийн бэлчээр ашиглалтын төлөвлөгөө, гэрээний хэрэгжилтийг хэлэлцэн, дараа жил хийх ажлыг төлөвлөх;

4.5. Сумын Засаг дарга дараах үйл ажиллагааг хэрэгжүүлнэ:

4.5.1. Сумын бэлчээр ашиглалтын төлөвлөгөөний хэрэгжилтийг зохион байгуулах, тайлагнах;

4.5.2. Сумын бэлчээр ашиглалтын төлөвлөгөөг үндэслэн Газрын тухай хуулийн 52 дугаар зүйлийн 52.2-т заасны дагуу БАХ-т бэлчээрийг болзол, гэрээгээр ашиглуулах, гэрээний хэрэгжилтийг дүгнэж, хариуцлага, үр дүнг тооцож ажиллах;

4.5.3. Багийн Засаг даргын ажлыг үнэлэхдээ тухайн жилийн бэлчээр ашиглалтын төлөвлөгөө болон энэ журмын хэрэгжилтийн үр дүнд үндэслэх;

4.5.4. Энэ журмыг мөрдөн ажиллаж байгаа баг, малчин өрх, БАХ-д давуу эрхтэйгээр хөрөнгө санхүү, бодлогын дэмжлэг үзүүлэх;

4.5.5. Гэрээнд заасны дагуу малын тоог бэлчээрийн даацад тохируулах нөхцөлийг удаа дараа хангаж байгаа БАХ-ийг Засгийн газрын 2017 оны 290 дүгээр тогтоолоор батлагдсан "Байгаль орчинд ээлтэй дэвшилтэт арга, технологи нэвтрүүлсэн иргэн, аж ахуйн нэгж, байгууллагыг урамшуулах журам"-д заасан байгаль орчинд ээлтэй дэвшилтэт арга, технологи нэвтрүүлсэн иргэн, аж ахуйн

нэгж, байгууллагад олгодог “Ногоон гэрчилгээ” олгуулахаар холбогдох байгууллагад уламжлах;

4.5.6. Гол, горхи, булаг, шандны эх ундаргыг хамгаалахаас бусад тохиолдолд бэлчээрийг хашиж хамгаалахгүй байх арга хэмжээг авах;

4.5.7. Сумын бэлчээрийн даац хүрэлцээтэй жил өөр аймаг, сумын нутгаас отроор өвөлжиж, хаваржих малыг оруулахдаа малчин өрхтэй байгуулсан гэрээгээр тохирсон төлбөрийг Бэлчээрийн санд оруулсны дараагаар бэлчээр нутгийг зааж өгөн нэвтрүүлэх;

4.5.8. Өмнөх жилийн гэрээний үүргээ биелүүлсний дараа буюу энэ журмын 1.2-т заасан зардлыг Бэлчээрийн санд төвлөрүүлснийг үндэслэн бэлчээр ашиглалтын гэрээг сунгах.

4.5.9. Газрын тухай хуулийн 52.8-д заасныг баримтлан гантай, эсхүл өвөлжилт хүндэрсэн багаас бэлчээрийн даац хүрэлцээтэй багийн нутаг дэвсгэрт айл өрх, мал сүргийг тухайн багийн Засаг даргатай зөвшилцөн оруулах шийдвэр гаргах;

4.5.10. Дараах саналыг аймгийн Ус, цаг уур, орчны шинжилгээний газарт хүргүүлнэ:

4.5.10.1. Тухайн багийн бэлчээр нутагт фотомониторингийн судалгаа хийж болох оновчтой цэгийг нэмж тогтоох;

4.5.10.2. Ургац муу бэлчээрт үүлэнд зориудаар нөлөөлөх генератор байрлуулах.

4.6. Багийн Засаг дарга дараахь үйл ажиллагааг хэрэгжүүлнэ:

4.6.1. Багийн тухайн жилийн бэлчээр ашиглалтын төлөвлөгөөг багийн Иргэдийн Нийтийн Хурлаар хэлэлцүүлэх, төлөвлөгөөний хэрэгжилтийг зохион байгуулах, тайлагнах;

4.6.2. Энэ журам, тухайн жилийн бэлчээр ашиглалтын төлөвлөгөө, БАХ-тай байгуулсан бэлчээр ашиглалтын гэрээний хэрэгжилтийг хянах;

4.6.3. Бэлчээр ашиглалтын гэрээнд заасны дагуу энэ журмын 1.2-т заасан зардлыг хурааж, энэ журмын 6.1-д заасан Бэлчээрийн сан (цаашид “Бэлчээрийн сан” гэх)-д төвлөрүүлэх;

4.6.4. Тухайн жилд Бэлчээрийн санд хуримтлагдсан хөрөнгөөр санхүүжүүлэхээр багийн Иргэдийн Нийтийн Хурлаас шийдвэрлэсэн ажлыг хэрэгжүүлэх.

Тав. Бэлчээрийг ашиглуулах

5.1. Иргэний хуулийн 481.1-т заасан бүртгэгдээгүй холбоо, нөхөрлөл буюу БАХ-ийн зохион байгуулалтад орсон малчдад сумын Засаг дарга бэлчээрийг Газрын тухай хуулийн 52.2-т заасны дагуу болзол, гэрээ (цаашид “бэлчээр ашиглалтын гэрээ” гэх)-гээр ашиглуулна.

5.2. БАХ, түүний гишүүн малчин дараах эрхийг эдэлнэ:

5.2.1. Бэлчээр ашиглалтын жилийн төлөвлөгөө боловсруулахад оролцох;

5.2.2. Бэлчээрийн сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэх арга хэмжээний талаар санал гаргах, уг арга хэмжээний явц, гүйцэтгэлд болон сангийн зарцуулалтын байдалд хяналт тавих;

5.2.2.1. Тухайн баг, сумын нутаг дэвсгэрийн 50-аас доошгүй хувь нь гантай байсан нь тогтоогдсон нөхцөлд нийт малчин өрхийг бэлчээр ашиглалтын татвараас чөлөөлөх тухай шийдвэрийг сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас гаргах.

5.2.2.2 Энэ журмын 6.3.4-т заасан төлбөрийн хэмжээ хонин толгой тутамд хоногт 50 төгрөгөөс хэтрэхгүй байна.

5.2.3 Дор дурдсан тохиолдолд малчин өрх, түүний мал бэлчээр ашиглалтын гэрээнд заасан малын тоог бэлчээрийн даацад тохируулах зохицуулалтад хамрагдахгүй байх:

5.3 БАХ, түүний гишүүн малчин бэлчээр ашиглахтай холбогдсон дараах үүргийг хүлээнэ:

5.3.1. Бэлчээрийг өнжөөж, чөлөөлөх, сэлгэх, отор нүүдэл хийх талаар гаргасан Засаг даргын шийдвэрийг дагаж биелүүлэх;

5.3.2. Бэлчээр ашиглалтын гэрээгээр тохирсны дагуу энэ журмын 1.2-т заасан зардлыг тухайн оны 6 дугаар сарын 01-ны өдрийн дотор төлж барагдуулах;

5.3.3. Өөр баг, сум, аймгаас дур мэдэн айл өрх, мал сүрэг оруулж ирэхгүй байх;

5.3.4. Өөр аймаг, сумын малчдад өвөлжөө, хаваржаа, хонд бууцыг дамжуулан ашиглуулахгүй байх;

5.3.5. Гэрээгээр ашиглаж байгаа бэлчээрт байгаа малын сэг, зэм, хог хаягдлыг цэвэрлэх;

5.3.6. Малаас чөлөөлсөн өвөлжөө, хаваржааны бэлчээрт заасан хугацаанд мал оруулахгүй байх;

5.3.7. Бэлчээр ашиглалтын төлөвлөгөөнд тусгасан бэлчээр ашиглалтын улирлын хуваарьт бэлчээрээс өөр бэлчээрт дур мэдэн нутаглахгүй байх;

5.3.8. Бэлчээрт хог хаягдал, хортой зүйлс, шавхай бууц, сэг зэмээр хашаа хороо, өтөг бууц, бэлчээр, усны эх үүсвэрийг бохирдуулахгүй байх;

5.3.9. Зуслан, намаржаа болон бэлчээр ашиглалтын төлөвлөгөөнд тусгаснаас өөр газар дур мэдэн өвөлжөө, хаваржаа барихгүй байх;

5.3.10. Бэлчээрийн даацаас илүү гарсан малыг тухайн жилийн мал тооллого хүртэлх хугацаанд зах зээлд борлуулах, цөөн тооны мал бүхий малчин өрхөд хөлсөөр маллуулан дэмжих, бэлчээрийн даац бүхий өөр аймаг, сумдын нутагт отроор явах;

5.3.11. Гэрээгээр ашиглаж байгаа бэлчээрийг хашихгүй байх.

5.3.12 Нийтээр ашиглах нөөц бэлчээр бүхий уст цэгийг малчид дундын хэрэгцээнд ашиглана.

5.3.13. Өөр аймаг, өөрийн аймгийн сумын малчдыг гэрээ, хэлэлцээр хийж өөрийн нутагт жилийн дөрвөн улиралд нутагласан тохиолдолд тухайн онд нутаг тавьж өгсөн газарт отор хийж заасан хугацаанд нутаг чөлөөлөх, чөлөөлөөгүй тохиолдолд албадан нүүлгэн шилжүүлэх арга хэмжээг зохион байгуулж байх.

Зургаа. Бэлчээрийн сан

6.1.Багийн бэлчээрийн санг Багийн иргэдийн Нийтийн Хурлын хуралдаанаар хэлэлцүүлэн батлуулж, тухайн санд мөнгөн хөрөнгийг төвлөрүүлнэ.

6.2. Багийн бэлчээрийн санг сумын бэлчээр ашиглагчдын холбоонд баг бүрийн тусгай тохиргоотой шилэн данс хэлбэрээр байршуулж болно.

6.3. Бэлчээрийн сан дараах эх үүсвэрээс бүрдэнэ:

6.3.1. Энэ журмын 1.2-т заасан зардал;

6.3.2. Мал аж ахуйн салбарын хөгжлийг дэмжих чиглэлээр хэрэгжүүлж байгаа төслийн хөрөнгө;

6.3.3. Бэлчээрийн санд аймгийн орон нутгийн хөгжлийн сангаас хуваарилсан тухайн багаас хуримтлагдсан хөрөнгийн хэмжээтэй тэнцэх хэмжээний хөрөнгө;

6.3.4. Энэ журмын 4.5.2-д заасны дагуу өөр аймаг, сумын нутгаас оруулсан малын хонин толгой тутамд гэрээгээр тохирсон мөнгөн төлбөр;

6.3.5. Хандив, тусламж, бусад эх үүсвэр.

6.4. Бэлчээрийн сангийн хөрөнгийг дараахь үйл ажиллагаанд зарцуулна:

6.4.1. Доройтсон, хэт доройтсон бэлчээрийг нөхөн сэргээхэд чиглэсэн үйл ажиллагаа (бусад малчдыг эрх ашгийг хөндөхгүйгээр);

6.4.2. Ашиглагдахгүй бэлчээрийг ашиглах зорилгоор хөв, цөөрөм, бэлчээрийн усан хангамжийг нэмэгдүүлэх;

6.4.3. Багийн хэмжээнд ашиглах хадлан тэжээлийн талбай бий болгох;

6.4.4. Бэлчээрийн хортон мэрэгчидтэй тэмцэх;

6.4.5. Бэлчээрт үүлэнд зориудаар нөлөөлөх зорилгоор генератор суурилуулах, түүнтэй холбоотой асуудлыг шийдвэрлэхэд /түлш авах, үүлэнд зориудаар нөлөөлөх/;

6.4.6. Бэлчээр дэх уст цэг, хужир мараа бүхий нийтээр ашиглах бэлчээрт мод, бут, сөөг тариалах,

6.5. Өөр аймаг сумд отроор яваа малчин өрхөд шаардлагатай бол сангаас дэмжлэг үзүүлж болно.

Долоо. Маргаан шийдвэрлэх, хохирол нөхөн төлүүлэх

7.1. Бэлчээр ашиглах асуудлаар гарсан аливаа маргааныг Газрын тухай хуулийн 52.10-т заасны дагуу багийн Иргэдийн Нийтийн Хурлаар хэлэлцэж зохицуулна. Эс тохиролцсон тохиолдолд сумын Засаг дарга шийдвэрлэнэ.

7.2. Бэлчээрт учирсан хохирлыг нөхөн төлөх асуудлыг Байгаль орчныг хамгаалах тухай хуулиар зохицуулна.

Найм. Хариуцлага хүлээлгэх, өөрчлөлт оруулах

8.1. Энэхүү журмыг зөрчсөн тохиолдолд Монгол улсын Зөрчлийн тухай хуулийн 8.1 дүгээр зүйлийн 6 дахь хэсэгт заасан хариуцлага хүлээлгэнэ.

8.2. Багийн Иргэдийн Нийтийн Хурлаас дэмжигдсэн саналыг сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд сумын Засаг дарга хэлэлцүүлж өөрчлөлт оруулна.

-----oOo-----

**БАЯНХОНГОР АЙМГИЙН БААЦАГААН СУМЫН
“БЭЛЧЭЭР АШИГЛАЛТЫГ ХАРИУЦЛАГАЖУУЛАХ ЖУРАМ”-ЫН
НӨЛӨӨЛЛИЙН ШИНЖИЛГЭЭ, ХЭЛЭЛЦҮҮЛГИЙН МЭДЭЭЛЭЛ
ХИЙСЭН ТАНИЛЦУУЛГА**

2022 оны 05 дугаар сарын 30.

Баянсайр

Сумын “Бэлчээр ашиглалтыг хариуцлагажуулах журам”-ыг боловсруулсан төслийг 2022 оны 05 дугаар сарын 18-наас 25-ны хооронд багуудын иргэдийн Нийтийн Хурлын хуралдаанаар хэлэлцүүлээ.

Багуудын иргэдийн Нийтийн Хурлын хуралдаанд сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дарга Ж.Ганбат, Засаг даргын Тамгын газрын дарга Б.Наранбаатар, Хөдөө аж ахуйн тасгийн мэргэжилтэн С.Батхүү, Байгаль орчны хяналтын Улсын байцаагч Э.Бат-Эрдэнэ, Татварын Улсын байцаагч А.Бүжинлхам, багуудын Засаг дарга, Иргэдийн Нийтийн Хурлын дарга нар байлцсан.

Энэ журам нь орон нутгийн бэлчээрийн экологийн чадавхид суурилсан аргачлалаар төлөвлөх, бэлчээрийн нөөц, даацад тохируулан байгалийн жамаараа нөхөн сэргэх боломжийг бүрдүүлсэн төлөвлөгөөний дагуу улирлын хуваарьтайгаар, зүй зохистой ашиглаж, хамгаалах дадлыг төлөвшүүлэх, бэлчээрийг өнжөөж чөлөөлөх, сэлгэх, отор нүүдэл хийх, бэлчээртэй холбогдсон харилцааг зохицуулахад чиглэгдсэн. Орон нутагт бороо хур орохгүй, ган зудын давтамж ихсэж, газрын гадаргын болон гүний усны нөөц хомстож, малчид малынхаа чанарт биш малын тооны араас хөөцөлдөж байгаа нь сүргийн бүтэц алдагдах, бэлчээрийн даац хэтрэх, бэлчээрийг байгалийн жамаараа нөхөн ургах боломж олгохгүй, талхлагдах, доройтох шалтгаан болсон.

Ийм учраас бэлчээрийг сайжруулах, малын тоо толгойг бэлчээрийн даацад тохируулан жил дараалан бууруулах, малын үүлдэр угсаа, чанарыг сайжруулах, ашиг шимийн гарцыг нэмэгдүүлэх, малын шилжилт хөдөлгөөнийг хязгаарлах, бэлчээрийг усжуулах, малын тэжээлийн ургамал тариалах, мал аж ахуй, газар тариаланг хослуулан хөгжүүлэх нь “Бэлчээр ашиглалтыг хариуцлагажуулах журам”-ыг боловсруулах, нөлөөллийн шинжилгээний танилцуулга, малчдын хэлэлцүүлэг хийх, улмаар сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын хуралдаанд хэлэлцүүлэн батлуулах үндэслэл болсон.

Багуудын иргэдийн Нийтийн Хурлын хуралдаанд хөдөөгийн 6 багийн 452 малчин оролцож, үг хэлж, санал бодлоо солилцож, малчид, иргэд чөлөөтэй санал шүүмжлэл өрнүүллээ.

Багуудын иргэдийн Нийтийн Хурлаар хэлэлцсэн асуудал:

1. “Бэлчээр ашиглалтыг хариуцлагажуулах журам”-ын төсөл, хэлэлцүүлгийн мэдээлэл хийсэн танилцуулга, малчдын санал хүсэлтийг тусгах,

2. “Бэлчээр ашиглалтыг хариуцлагажуулах журам”-ын нөлөөллийн шинжилгээний танилцуулга,

3. Малын тоо толгойн албан татварын хуулийн талаар

С.Батхүү /Сумын Хөдөө аж ахуйн тасгийн мэргэжилтэн/: “Бэлчээр ашиглалтыг хариуцлагажуулах журам”-ын төсөл, “Бэлчээр ашиглалтыг хариуцлагажуулах журам”-ын нөлөөллийн шинжилгээний танилцуулгын талаар хэлэлцүүлэг зохион байгуулж, тайлбарлан ярьж, журмын төсөл, танилцуулгад малчдын санал хүсэлтийг тусгах, хурлыг ирцийг бүртгэх, хуралд ирсэн малчдаар гарын үсэг зуруулж баталгаажуулах, санал шүүмжлэлийг бичиж авах, хурлын тэмдэглэл хөтөлсөн.

А.Бүжинлхам /татварын Улсын байцаагч/: Малын тоо толгойн албан татварын хууль, татвар оногдуулалт, хураалт, төсөв бүрдүүлэх, зарцуулах талаар дэлгэрэнгүй мэдээлсэн.

Хэлэлцэж байгаа асуудалтай холбогдуулан:

Баянбулаг багийн малчин Б.Мөнх-Эрдэнэ, Б.Жамбалбавуу, Г.Галбадрах, Р.Ганбаатар, П.Цэрэнжамц, Ц.Пүрэвсүрэн, Ч.Гантулга, Д.Содномпил нар,

Оройн бууц багийн малчин Х.Даваадорж, Н.Алтангэрэл, Б.Билэгдэмбэрэл, Ц.Ганбаатар, Б.Батмөнх, Б.Батсайхан, С.Гомбосүрэн, З.Мөнхбат, Н.Алтансүх нар

Буйлсан багийн малчин Б.Чойдорж, Б.Идэрмөнх, Т.Цогнэмэх, Б.Дэлгэрдалай, Л.Батчулуун, Ц.Цэрэнтогтох, Ч.Шатарпүрэв, Ү.Төгсжаргал, Б.Ёндон нар,

Могойн багийн малчин Д.Батсуурь, Б.Тайваннямбуу, Г.Батдамба, У.Түмэн, П.Түмэнжаргал, Ц.Хүрэлбаатар, Д.Минжүүржав, Х.Нямлхагва, З.Ганхүү нар,

Товгор багийн малчин А.Батжаргал, Б.Мягмаргармаа, Б.Баасанхүү, Р.Даваадагва, Ж.Нэргүйчимэг, Н.Түмэндэмбэрэл, П.Тэгшээ, М.Үйтүмэн, С.Очиржав нар,

Зүүнхаяа багийн малчин Б.Хүрэлсүх, Б.Авид, Д.Мөнхбаатар, Д.Батбаяр, Ц.Ганбат, Б.Санжаа, Ч.Төрбат, С.Сандагдорж, С.Доржсүрэн нар, багуудын хуралд нийт 452 малчин оролцсоноос 11,7 хувь буюу 53 малчин үг хэлж, санал бодлоо илэрхийлж, “Бэлчээр ашиглалтыг хариуцлагажуулах журам”-ын төсөл, “Бэлчээр ашиглалтыг хариуцлагажуулах журам”-ын нөлөөллийн шинжилгээний танилцуулга, Малын тоо толгойн албан татварын хуулийн талаар дэлгэрэнгүй мэдээлэл өгсөн.

Малын тоо толгойн татварын хувь хэмжээг тоолуулсан малын тоотой нь уялдуулан тогтоох, бороо хур орохгүй, газрын гарц муутай жил малын тоо толгойн албан татвараас хөнгөлөх талаар малчин, иргэд санал бодлоо илэрхийлж, төр засаг анхааралдаа авч аливаа шийдвэр гаргах нь зүйтэй байгааг уламжилсан.

Дүгнэлт: “Бэлчээр ашиглалтыг хариуцлагажуулах журам”-ын төсөл, Нөлөөллийн шинжилгээний танилцуулгыг багуудын иргэдийн Нийтийн Хурлын хуралдаанд оролцсон малчдын 70-80 хувь нь бүрэн дэмжиж байсан тул сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2022 оны 12 дугаар сарын ээлжит хуралдаанаар хэлэлцүүлэн батлуулахаар шийдвэрлэсэн.

“Бэлчээр ашиглалтыг хариуцлагажуулах журам”, нөлөөллийн шинжилгээний танилцуулга, хэлэлцүүлгийн танилцуулгыг хэрэгжүүлснээр бэлчээрийн нөхөн сэргэлт сайжирч, мал сүргийн бүтэц сайжирч, бэлчээрийн даацад тохируулан мал сүргээ өсгөж, малын шилжилт хөдөлгөөнийг хязгаарлаж, малын халдварт, гоц халдварт өвчний гаралт буурна гэж тооцож байна. Улмаар “Бэлчээр ашиглалтыг хариуцлагажуулах журам”, Нөлөөллийн шинжилгээний танилцуулга, малчдын хэлэлцүүлэг, хэлэлцүүлэгт оролцсон малчдын гарын үсэг, хэлэлцүүлгийн мэдээлэл хийсэн танилцуулга болон бусад баримт бичгийг бүрдүүлэн Хууль зүйн яамаар батлуулан, хэрэгжүүлж ажиллахаар шийдвэрлэсэн.

ТАНИЛЦУУЛГА ХИЙСЭН:
ХӨДӨӨ АЖ АХУЙН ТАСГИЙН
МЭРГЭЖИЛТЭН

С.БАТХҮҮ